



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: БНА-2021/118/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цээням:

Утас: 70442424 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)


Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljmaab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал



## Агуулга

1.Төрийн аудитын санал дүгнэлт /эх хувь/ .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3.Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.9. Аудитын илрүүлэлт .....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	16
Аудитын зөвлөмж .....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	17
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН Г  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
З.ЦЭРЭНДОРЖ ТАНАА

2021.02.25 № 2198

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан биелэлтийг тооцон ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 A4 TOOT

• 005020088

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,536,550.00</b>	<b>71,811,958.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,400,000.00</b>	<b>100,208.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	100,208.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>3,400,000.00</b>	<b>00.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	3,400,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>15,136,550.00</b>	<b>71,711,750.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>15,136,550.00</b>	<b>71,711,750.00</b>
35420	Аж ахуйн материал	603,800.00	499,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	4,000,000.00
35450	Барилгын засварын материал	00.00	1,633,900.00
35470	Бусад хангамжийн материал	14,532,750.00	65,578,850.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>952,804,572.27</b>	<b>902,723,718.06</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>952,804,572.27</b>	<b>902,723,718.06</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>940,336,114.23</b>	<b>890,092,759.98</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	638,285,941.90	653,365,941.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-66,802,333.32	-88,216,055.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	117,244,800.00	94,744,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-71,898,076.14	-64,167,058.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	201,042,040.10	209,806,180.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-45,927,592.85	-78,706,459.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,468,555.91	49,468,555.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,059,981.89	-33,894,986.21
39214	Бусад үндсэн хөрөнгө	286,381,090.00	301,641,090.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-137,518,329.48	-154,069,248.84
39217	Ном	120,000.00	120,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>12,468,458.04</b>	<b>12,630,958.08</b>
39301	Програм хангамж	3,800,000.00	3,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,199,999.96	-1,937,499.92
39303	Бусад биет бус хөрөнгө	10,868,458.00	10,868,458.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>971,341,122.27</b>	<b>974,535,676.06</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>971,341,122.27</b>	<b>974,535,676.06</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>971,341,122.27</b>	<b>974,535,676.06</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	382,993,124.00	382,993,124.00
51101	Өмч: - төрийн	382,993,124.00	382,993,124.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>237,099,671.35</b>	<b>240,294,225.14</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	237,099,671.35	237,099,671.35
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	3,194,553.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	351,248,326.92	351,248,326.92
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>971,341,122.27</b>	<b>974,535,676.06</b>

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
СОРОМЦГУЙ  
САНАД ГҮВЭЭНИЙ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>475,854,554.00</b>	<b>509,688,300.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>174,952,901.00</b>	<b>115,062,640.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>174,952,901.00</b>	<b>115,062,640.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	174,952,901.00	115,062,640.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	700,000.00	700,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	148,500.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	174,104,401.00	114,362,640.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>300,901,653.00</b>	<b>394,625,660.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,500,000.00</b>	<b>25,715,460.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,500,000.00	14,635,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	8,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,380,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>292,363,200.00</b>	<b>368,910,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	292,363,200.00	368,910,200.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>38,453.00</b>	<b>00.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	38,453.00	00.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>335,193,297.29</b>	<b>500,967,057.41</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>335,193,297.29</b>	<b>500,967,057.41</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>333,909,541.29</b>	<b>497,721,717.41</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>195,250,267.00</b>	<b>242,654,304.00</b>
210101	Үндсэн цалин	195,250,267.00	211,132,869.00
210102	Нэмэгдэл	00.00	31,521,435.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>23,574,551.00</b>	<b>28,891,415.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,574,551.00	28,891,415.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>17,461,044.00</b>	<b>18,291,901.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,961,944.00	6,940,286.00
210302	Түлш, халаалт	14,499,100.00	11,351,615.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,004,100.00</b>	<b>31,774,790.00</b>
210401	Бичиг хэрэг	2,735,520.00	4,996,590.00
210402	Тээвэр, шатахуун	14,709,100.00	25,557,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	615,180.00	335,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	145,000.00	143,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	799,300.00	741,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,679,500.00</b>	<b>1,929,929.00</b>
210602	Тавилга	55,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,624,500.00	1,929,929.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,046,000.00</b>	<b>7,046,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,046,000.00	7,046,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,000,000.00	00.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>19,272,584.00</b>	<b>26,058,023.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,708,584.00	22,194,023.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>46,621,495.29</b>	<b>141,075,355.41</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,673,351.00	56,527,050.00

**Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	140,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,848,144.29	84,408,305.41
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,283,756.00</b>	<b>3,245,340.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,038,453.00</b>	<b>1,500,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,038,453.00	1,500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>245,303.00</b>	<b>1,745,340.00</b>
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	00.00	510,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	245,303.00	1,235,340.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>140,661,256.71</b>	<b>8,721,242.59</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>16,228,752.12</b>	<b>5,526,688.80</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	16,228,752.12	5,526,688.80
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-16,228,752.12</b>	<b>-5,526,688.80</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>124,432,504.59</b>	<b>3,194,553.79</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/ /Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>301,750,153.00</b>	<b>395,325,660.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>848,500.00</b>	<b>700,000.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	848,500.00	700,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	848,500.00	700,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	700,000.00	700,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	148,500.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>300,901,653.00</b>	<b>394,625,660.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,500,000.00	25,715,460.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,500,000.00	14,635,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	8,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,380,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>292,363,200.00</b>	<b>368,910,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	292,363,200.00	368,910,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>38,453.00</b>	<b>00.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	38,453.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>301,750,153.00</b>	<b>391,745,660.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>301,750,153.00</b>	<b>391,745,660.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>300,466,397.00</b>	<b>388,500,320.00</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,547,390.00	242,654,305.00
210101	Үндсэн цалин	159,666,107.00	199,403,051.00
210102	Нэмэгдэл	34,881,283.00	43,251,254.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,277,428.00</b>	<b>28,991,622.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	16,436,400.00	19,214,722.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,960,500.00	2,493,711.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,568,300.00	1,944,813.00
210204	Ажилгүйдлийн даатгал	391,328.00	482,777.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,920,900.00	4,855,599.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,461,044.00	18,291,901.00

**Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210301	Гэрэл, цахилгаан	2,961,944.00	2,836,240.00
210302	Түлш, халаалт	14,499,100.00	15,455,661.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,028,900.00</b>	<b>36,094,290.00</b>
210401	Бичиг хэрэг	2,506,700.00	4,227,900.00
210402	Тээвэр, шатахуун	14,559,100.00	29,557,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	964,000.00	1,349,590.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	299,100.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,000.00	599,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,000,000.00</b>	<b>5,730,400.00</b>
210602	Тавилга	5,005,500.00	00.00
210604	Урсгал засвар	1,994,500.00	5,730,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,046,000.00</b>	<b>7,046,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,046,000.00	7,046,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,000,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,282,284.00</b>	<b>27,181,952.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,645,784.00	23,245,452.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,500.00	22,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,823,351.00</b>	<b>22,509,850.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,723,351.00	21,509,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	1,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,283,756.00</b>	<b>3,245,340.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,038,453.00</b>	<b>1,500,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,038,453.00	1,500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>245,303.00</b>	<b>1,745,340.00</b>
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	00.00	510,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	245,303.00	1,235,340.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>3,580,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>3,580,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>3,580,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>3,580,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	3,580,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-3,580,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

ТОРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЭБЭРЧИЛГҮЙ  
САНХҮҮГИЙН

**Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**


/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,800,666.00	340,970,392.00	147,223,178.73	866,994,236.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	378,800,666.00	340,970,392.00	147,223,178.73	866,994,236.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	4,192,458.00	00.00	9,076,931.97	13,269,389.97
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,993,124.00	351,248,326.92	237,099,671.35	971,341,122.27
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,993,124.00	351,248,326.92	237,099,671.35	971,341,122.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	382,993,124.00	351,248,326.92	237,099,671.35	971,341,122.27
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,194,553.79	3,194,553.79
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,993,124.00	351,248,326.92	240,294,225.14	974,535,676.06

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	370,410,200.00	368,374,860.00	-2,035,340.00	99.5
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	370,410,200.00	368,374,860.00	-2,035,340.00	99.5
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	368,910,200.00	366,874,860.00	-2,035,340.00	99.4
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	243,603,700.00	242,654,305.00	-949,395.00	99.6
210101	Үндсэн цалин	200,415,000.00	199,403,051.00	-1,011,949.00	99.5
210102	Нэмэгдэл	43,188,700.00	43,251,254.00	62,554.00	100.1
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,264,100.00	28,991,622.00	-272,478.00	99.1
210201	Тэтгэврийн даатгал	19,259,900.00	19,214,722.00	-45,178.00	99.8
210202	Тэтгэмжийн даатгал	2,501,000.00	2,493,711.00	-7,289.00	99.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,000,900.00	1,944,813.00	-56,087.00	97.2
210204	Ажилгүйдлийн даатгал	500,200.00	482,777.00	-17,423.00	96.5
210205	Эрүүл мэндийн даатгал	5,002,100.00	4,855,599.00	-146,501.00	97.1
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,293,500.00	18,291,901.00	-1,599.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,245,300.00	2,836,240.00	-409,060.00	87.4
210302	Түлш, халаалт	15,048,200.00	15,455,661.00	407,461.00	102.7
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	36,095,200.00	36,094,290.00	-910.00	100.0
210401	Бичиг хэрэг	4,228,500.00	4,227,900.00	-600.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	29,557,000.00	29,557,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,349,700.00	1,349,590.00	-110.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	360,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	599,800.00	-200.00	100.0

**Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,080,400.00	7,080,400.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	850,000.00	850,000.00	#DIV/0!
210604	Урсгал засвар	7,080,400.00	6,230,400.00	-850,000.00	88.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	7,046,600.00	7,046,000.00	-600.00	100.0
210702	Дотоод албан томилолт	7,046,600.00	7,046,000.00	-600.00	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,326,700.00	10,516,492.00	-810,208.00	92.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,390,200.00	6,579,992.00	-810,208.00	89.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,500.00	22,500.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	0.00	100.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	16200000.00	16199850.00	-150.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,200,000.00	15,199,850.00	-150.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1500000.00	1500000.00	0.00	100.0
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	370,410,200.00	368,374,860.00	-2,035,340.00	99.5
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	369,410,200.00	367,674,860.00	-1,735,340.00	99.5
132001	Орон нутгийн төсвөөс	369,410,200.00	367,674,860.00	-1,735,340.00	99.5
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,000,000.00	700,000.00	-300,000.00	70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	700,000.00	-300,000.00	70
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	22.00	22.00	0.00	100
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00	0.00	100
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	22.00	22.00	0.00	100
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	09.00	09.00	0.00	100
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00	0.00	100
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	07.00	07.00	0.00	100


 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
 ЗСР/АК/РҮН  
 САЛГАА АУДИТЧИД

## **2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

/ төгрөгөөр /				
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0</b>	<b>25,205,460.00</b>	<b>25,205,460.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0</b>	<b>25,205,460.00</b>	<b>25,205,460.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0</b>	<b>25,205,460.00</b>	<b>25,205,460.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>0</b>	<b>16,665,460.00</b>	<b>16,665,460.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	16,665,460.00	16,665,460.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0</b>	<b>8,540,000.00</b>	<b>8,540,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	8,540,000.00	8,540,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0</b>	<b>25,715,460.00</b>	<b>25,715,460.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0</b>	<b>25,715,460.00</b>	<b>25,715,460.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	14,635,460.00	14,635,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	8,700,000.00	8,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	2,380,000.00	2,380,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

## **3.Аудитын тайлан**

### **3.1. Ерөнхий зүйл**


Жинст сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч З.Цэрэндорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдлийг сайжруулж, е-баримтыг үндэслэн зардлыг олгох, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, байгууллагын даргын тушаалын дагуу хөрөнгийг актлах, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг санхүүгийн программд дахин нягтлах зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Жинст сумын ЗДТГ 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2021.01.22-ний өдөр ирүүлсэн байна.



### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллага “Төрийн үйлчилгээг ард иргэдэд хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэж, сумын эдийн засгийн өсөлтийг тогтвортой хөгжүүлэн, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах” эрхэм зорилго тавьж ажилласан байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд тайланд онд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Сахилга хариуцлага, ёс зүйг эрхэмлэн дээдэлж, ур чадвартай, зөв манлайлалтай байж ил тод, түргэн шуурхай, эелдэг харилцаатай, соёлтой үйлчилгээг ард иргэдэд үзүүлнэ. Үүний тулд:

- Хорт зуршилгүй, гэмт хэрэг зөрчилгүй хамт олон болно.
- Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөнө.
- Мэдлэг ур чадвараа хөгжүүлэн, зөв манлайлалтай байна.
- Мэдээллийн ил тод нээлттэй түргэн шуурхай үйлчилгээг хэвшүүлнэ зэрэг болно.

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:


- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Жинст сумын ЗДТГ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор хийж гүйцэтгэлээ.



Жинст сумын ЗДТГ нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Acolous санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, байгууллагын нярваар 219.2 мянган төгрөгийн шатахууны үнийг төлүүлэх, зөрүүтэй тооцож олгосон цалингийн 395.7 мянган төгрөгийг ажиллагсдаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосныг төлж барагдуулсан байна.

Жинст сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг үр дүнгийн тайлангийн зардлын 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 03 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2 хувиар буюу 3411.2 мянган төгрөгөөр тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн зардлын 2 хувиар буюу 10129.9 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс 6718.7 мянган төгрөгөөр их байгаа нь 4 дүгээр улиралд зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жинст сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 974535.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 3194.6 мянган төгрөгөөр буюу 0.33 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	18,536.6	71,812.0	53,275.4
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	3,400.0	100.2	(3,299.8)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	15,136.6	71,711.8	56,575.2
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	952,804.6	902,723.7	(50,080.9)
Үндсэн хөрөнгө	1,307,210.9	1,323,715.0	16,504.1
Хуримтлагдсан элэгдэл	(354,406.3)	(420,991.3)	(66,585.0)
<b>Нийт хөрөнгө</b>	971,341.1	974,535.7	3,194.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	971,341.1	974,535.7	3,194.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	971,341.1	974,535.7	3,194.6

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 2 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эхний “Цэсда” ХХК-аас авах 3400.0 мянган төгрөгийн сумын ЗДТГ-ын зураг төсвийн үнийн авлагыг тайлант онд барагдуулсан бөгөөд оны эцэст 100.2 мянган

төгрөгийн авлагатай гарсан нь группт орсон болон тэтгэвэрт гарсан хүмүүсийн нийгмийн даатгалын шимтгэлийн кодын зөрүүнээс үүссэн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 71711.8 мянган төгрөг болж өмнөх оноос 56575.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сумын ОНХС-ийн хөрөнгөөр 6000.0 мянган төгрөгөөр ном хэвлүүлсэн, 72088.5 мянган төгрөгийн өвс тэжээлийг үнэ төлбөргүйгээс орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оны эцэст 1307210.9 мянган төгрөг байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 3580.0 мянган төгрөгийн 6 үндсэн хөрөнгө худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийг сумын Засаг даргын 2020.12.28-ний өдрийн а/147 дугаар захирамжаар орлогод авч, тайлант онд нийт 36274.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй ирснийг орлогоор бүртгэж, аймгийн ИТХ-ын 20 дугаар тогтоолоор Ланд круйзер 80 маркын 22500.0 мянган төгрөгийн суудлын автомашиныг дуудлага худалдаагаар худалдаж балансаас хассан ба дуудлага худалдааг аймгийн Орон нутгийн өмчийн газар зохион байгуулжээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.11.06-ний өдрийн 108 дугаар тогтоолоор 200.0 мянган төгрөгийн архивын, 200.0 мянган төгрөгийн төрийн сангийн, 450.0 мянган төгрөгийн багийн программыг биет бус хөрөнгөөс хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 3194.6 мянган төгрөгөөр нэмэгдэж 974535.7 мянган төгрөг болсон байна.

Жинст сумын ЗДТГ-ын улсын төсвөөс авах санхүүжилт өмнөх оноос 77046.6 мянган төгрөгөөр буюу 26.3 хувиар өссөн бөгөөд, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого өмнөх оноос 400.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 1000.0 мянган төгрөг болжээ.

Нийт зардал өмнөх онд 292717.9 мянган төгрөг байсан бол тайлант оны зардал өмнөх оноос 75656.9 мянган төгрөгөөр буюу 25.8 хувиар өсөж, 368374.8 мянган төгрөг гарсан нь өмнөх оны үзүүлэлтээс урсгал шилжүүлгийг 11136.9 мянган төгрөгөөр бууруулж, бараа үйлчилгээний зардлыг 75656.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 397987.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 25577.3 мянган төгрөгөөр бууруулж, 372410.0 мянган төгрөгийг баталж, тайлант онд 9 дүгээр сард 2000.0 мянган төгрөгөөр хасах тодотгол хийж, 12 дугаар сард цалингийн зардлыг 6500.0 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2499.9 мянга, томилолтын зардлыг 3000.0 мянга, нийт 11999.9 мянган төгрөгөөр бууруулж, хангамж бараа материалын зардлыг 6999.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 5000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Анхны батлагдсан төсөв	2020 оны 12 сард зохицуулалт хийсэн төсөв
348625.3	370410.2

Тус байгууллагад ЗДТГ-т 17, багт 5 орон тоо баталснаас гүйцэтгэлээр 22 орон тоогоор ажилласан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 369410.2 мянга, өөрийн орлогоор 1000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 368910.2 мянга буюу батлагдсан төсвөөс 1500.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч, үндсэн үйл ажиллагааны орлогоор 700.0 мянган төгрөг оруулж, урсгал үйл ажиллагаанд 368374.9 мянган төгрөгийг зарцуулан, оны эцэст 1235.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 25715.4 мянган төгрөгийн орлого орсноос 25205.4 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 510.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ.

Хүснэгт 2. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Хугацаа хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	11	11	11			
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	95	1		11 дүгээр сард хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр
	Нийт	27	151	150	1	0	

Эх сурвалж: Жинст сумын ЗДТГ-ын шилэн данс

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитыг аудитор Г.Ганчимэг хийж гүйцэтгэн, аудитаар илэрсэн 18300.0 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж, 972.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 750.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгснөөс 2012 онд “Тогтвортой амьжиргаа” төслөөс үнэ төлбөргүй олгосон 12.9 сая төгрөгийн Кама маркын хог тээврийн машины авто тээврийн хэрэгслийн бичиг баримтыг байгууллагын нэр дээр болгох зөвлөмжийг биелүүлж ажиллаагүй байгаа нь тухайн автомашин явахгүй байгаа тул актлуулах саналыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт тавьсан байна.

Аудитын тайланд аудитын зөвлөмжийг хариуг 2020.06.01-ний дотор төрийн аудитын байгууллагад ирүүлэхээр заасан байхад хугацааг хоцроож, зөвлөмжийн хариуг 2020.06.18-ний өдрийн 95 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Иймд цаашид аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, хариуг хугацаанд нь гаргаж, холбогдох нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад ирүүлж байх шаардлагатай байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 75137.0 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар шийдвэрлэв.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 75137.0 мянган төгрөгийн 7 залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2085.3 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 52683.6 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 20368.1 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

1. Оны эцэст цалингийн зардлыг бууруулж, шатахууны зардалд нэмж тодотгол хийж, "НИК" ХХК-д 4000.0 мянган төгрөгийг шилжүүлж, шатахууны үлдэгдэлтэй гарч бараа материал нөөцөлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагаар 2000.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Жинст сумын Засаг даргын захирамжаар сумын малчид, төлчдийн зөвлөгөөн зохион болон цэргийн тоо бүртгэл зохион байгуулах арга хэмжээнд 1706.0 мянган төгрөгийн бөхийн бай шагнал олгосон байхад 85.3 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаж төсөвт төвлөрүүлээгүй байна.


Шийдвэрлэсэн нь: Суутган тооцоогүй 85.3 мянган төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогч нараа төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Тайлант онд 72088.5 мянган төгрөгийн өвс тэжээл үнэ төлбөргүй авч, 38199.2 мянган төгрөгийн өвс тэжээл зарлагадсан ба өвс тэжээлийн үнийг нярвын дансаар дамжсан ба аудитын явцад авсан тодруулгаар Сум дундын ойн анги тус суманд 77578.6 мянган төгрөгийн өвс тэжээл нийлүүлж, 24895.0 мянган төгрөгийн үнийг дансанд авч, 52683.6 мянган төгрөгийн авлагатай гэж гарсан боловч сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд өвс тэжээлийн авлага, өглөг тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өвс тэжээлийн тооцоог бодож, үнийг байгууллагын дансаар дамжуулан авч, Сум дундын Ойн ангитай тооцоо нийлэх албан шаардлагыг хүргүүлэв.

4. Жинст сумын Засаг даргын 2020.01.23-ний өдрийн а/17 дугаар захирамжаар сумын малчид, төлчдийн зөвлөгөөн зохион байгуулах зардалд 1500.0 мянган төгрөгийг зарцуулах, 2020.06.26-ний өдрийн а/64 дүгээр захирамжаар хамтарсан багийн үйл ажиллагаа, үйлчилгээний зардалд 1500.0 мянган төгрөгийг зарцуулах, 2020.07.10-ний өдрийн А/28 дугаар захирамжаар албан хаагчдын туршлага судлах аяллын зардалд зарцуулах 4000.0 мянган төгрөгийн захирамжийг болон таван сая төгрөгөөс дээш 25040.0 мянган төгрөгийн 4 ажил гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хоцроосон мэдээллийг байгууллагын шилэн дансанд нөхөн байршуулах албан шаардлагыг хүргүүлэв.



## **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 20368.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Өвс тэжээлийн тооцоог нярвын дансаар дамжуулсан асуудлыг цаашид анхаарах шаардлагатай байна.

## **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **1. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

1.1. **Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгөд өмнөх онуудад нэхий бээлий, арьсан бээлий, салхины шил, хамгаалалтын дуулга, 2020 онд 60.0 мянган төгрөгийн шаланк гэх мэт үндсэн хөрөнгийн шинж чанаргүй хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн, 2019.01.01-нд ашиглалтад орсон 3855.6 мянган төгрөгийн 3-р багийн төвийн ашиглагдах хугацааг - 1ээр сонгосноос үндсэн хөрөнгөд элэгдэл тооцоогүй ба өмнөх оны санхүүгийн тайлангаар хөрвүүлсэн СТАУС программд тус хөрөнгийг 4 жил ашиглахаар оруулж, 963.9 мянган төгрөгийн элэгдэл бодогдсон байна. Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү оны эхэнд 351248.3 мянган төгрөг байсан нь тайланд онд өөрчлөгдөөгүй бөгөөд СТАУС-аар татагдсан үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүйд зарим хөрөнгийн дахин үнэлгээний дүн хасах тэмдэгтэй байгаа ба дахин үнэлгээний нийт дүн 7396.9 мянган төгрөг байна.

1.2. **Эрсдэл:** Хөрөнгийн шинж чанарын дагуу зөв дансанд бүртгэхгүй байх, үндсэн хөрөнгөд элэгдэл тооцохгүй байх.

1.3. **Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгөд бүртгэсэн бараа материалыг зөв ангилж бүртгэх, үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг санхүүгийн программд зөв оруулж, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг аймгийн Орон нутгийн өмчийн газраас тодруулж, санхүүгийн программд зөв илэрхийлэх.

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

### **2. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

2.1. **Илрүүлэлт:** Мөнгөн гүйлгээний журналын анхан шатны баримттай тулган шалгахад 14504.0 мянган төгрөгийн гүйлгээний анхан шатны баримт байхгүй, е-баримтгүй хийсэн гүйлгээний тоо их, нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул, холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.

2.2. **Эрсдэл:** Нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт сулрах, анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлэх.

2.3. **Өгсөн зөвлөмж:** Төрийн сангийн төлөөлөгч харилцагч байгууллагаас ирүүлсэн е-баримтыг үндэслэн гүйлгээг хийх, анхан шатны баримтын бүрдэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулах.

2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

3. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

- 3.1. **Илрүүлэлт:** Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2020.10.06-ны өдрийн 02 дугаар хуралдаанаар 1948.5 мянган төгрөгийн 200 боодол өвс, 4 шуудай хивэг актлах шийдвэр гаргасан ба байгууллагын даргын шийдвэр гаргаагүй дээрх хөрөнгийг акталсан ба акталж устгасан баримт материалыг анхан шатны баримтад үдээгүй байна.
- 3.2. **Эрсдэл:** Агуулахад байхгүй хөрөнгийг акталснаар тайлагнасан байх, тушаал шийдвэргүйгээр хөрөнгийг акталсан байх.
- 3.3. **Өгсөн зөвлөмж:** Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн байгууллагын даргын гаргасан тушаалын дагуу хөрөнгийг акталж, устгал хийсэн баримт материалыг анхан шатны баримтад хавсаргаж байх.
- 3.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР .....




Б.ДОЛЖМАА

Огноо: 2021.02.25

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН  
МЕНЕЖЕР .....



А.ЦЭЭНЯМ

Огноо: 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР .....



Б.МӨНХБАТ

Огноо: 2021.02.25



## 5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Жинст сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021.02.25			БНА-2021/118/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Жинст сумын Засаг даргын Тамгын газар</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Оны эцэст шатахууны зардалд нэмж тодотгол хийж, НИК ХХК-д 4000.0 мянган төгрөгийг шилжүүлж, шатахууны үлдэгдэлтэй гарч бараа материал нөөцөлсөн.	2000.0	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
2	Жинст сумын Засаг даргын захирамжаар бөхийн бай шагнал олгосон 1706.0 мянган төгрөгөөс 85.3 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаж төсөвт төвлөрүүлээгүй.	85.3	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
3	Тайлант онд худалдан борлуулсан өвс тэжээлийн үнийг нярвын дансаар дамжуулсан ба аудитын явцад аймгийн Сум дундын ойн ангиас авсан тодруулгаар тус ангиас Жинст суманд 77578.6 мянган төгрөгийн өвс тэжээл нийлүүлж, 24895.0 мянган төгрөгийн үнийг дансанд авч, 52683.6 мянган төгрөгийн авлагатай гэсэн тооцооллыг гаргаж өгсөн байхад сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд өвс тэжээлийн авлага, өглөг байхгүй.	52683.6	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
4	Жинст сумын Засаг даргын 2020.01.23-ний өдрийн а/17, 2020.06.26-ний өдрийн а/64, 2020.07.10-ний өдрийн А/28 дугаар захирамжийг болон таван сая төгрөгөөс дээш 25040.0 мянган төгрөгийн 4 ажил гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй.	0	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
5	Мөнгөн гүйлгээний журналын анхан шатны баримттай тулган шалгахад 14504.0 мянган төгрөгийн гүйлгээний анхан шатны баримт байхгүй, е-баримтгүй хийсэн гүйлгээний тоо их, нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул, холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй.	14504.0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат

**Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

6	Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2020.10.06-ны өдрийн 02 дугаар хуралдаанаар 1948.5 мянган төгрөгийн 200 боодол өвс, 4 шуудай хивэг актлах шийдвэр гаргасан ба байгууллагын даргын шийдвэр гаргаагүй дээрх хөрөнгийг акталсан ба акталж устгасан баримт материалыг анхан шатны баримтад үдээгүй.	1948.5	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
7	Үндсэн хөрөнгөд бараа материал бүртгэсэн, үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацааг буруу оруулснаас элэгдэл бодогдоогүй, санхүүгийн программаас хөрвүүлсэн СТАУС-ын файлд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний дүнг шалгахад санхүүгийн байдлын хөрөнгийн дахин үнэлгээний дүнгээс зөрүүтэй.	3915.6	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	З.Цэрэндорж, М.Мөнхбат
<b>ДҮН</b>		<b>75137.0</b>			

---oOo---